



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн хяналтын тооллого хийх
ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлын үндсэн хөрөнгийн бүртгэлийг биетээр байгаа хөрөнгөтэй тулгах, нийцэж байгаа эсэхийг нягтлах, хяналтын тооллого хийх ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эд хөрөнгийн хяналтын тооллогыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд холбогдох хууль тогтоомжийн дагуу баримтуудыг үндэслэн үнэн зөв чанартай хийж, үлдэгдлийг баталгаажуулан, 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дотор тайлагнахыг ажлын хэсэг (Х.Баярмаа)-т үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн гишүүдийг тооллого хийх нөхцөл бололцоогоор хангаж, шаардлагатай тохиолдолд холбогдох ажилтнуудыг оролцуулж, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар, нэгжийн удирдлагуудад даалгасугай.

4. Тооллогын явцад илүү цагаар ажилласан ажилтны ажлын цагийн зохицуулалтыг хийж, биеэр амраах арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Хатанбаатар), Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн
А/134 дугаар тушаалын ... дугаар хавсралт



Хяналтын тооллого, бүртгэл хийх
ажлын хэсгийг бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн
дарга:

Х.Баярмаа

(Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий хянагч
бөгөөд ерөнхий нягтлан бодогч)

Гишүүд:

Н.Баярмаа

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн
засаг төлөвлөлтийн газрын ерөнхий нягтлан бодогч)

Т.Батаа

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн
засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч)

Д.Лхагвасүрэн

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн
засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч)

Э.Отгонбаяр

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн
засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч)

М.Энхжин

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн
засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч)

У.Нямцэцэг

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн
засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч)

Л.Мөнхцэцэг

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн
засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч)

Б.Мөнхсайхан

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн
засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч)

Д.Насандэлгэр

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын хангамжийн мэргэжилтэн)

А.Чойжамц

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын хангамжийн мэргэжилтэн)

Б.Энхтайван

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын нярав)

Б.Энхцэцэг

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын нярав)

Б.Отгонтуул


(Холбоо, навигаци, ажиглалтын албаны Санхүү хангамжийн хэсгийн ахлах нягтлан бодогч)

Нарийн бичгийн
дарга:

Д.Хишигсүрэн

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч)

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 14 ны өдрийн
А/134 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**Эд хөрөнгийн хяналтын тооллого хийх
ажлын хэсгийн ажлын удирдамж**

1. Зорилго

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн №382 тоот тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн бүртгэлд тусгасан Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон Монгол улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлсэн Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны буудлын 1,264,630,635,276.04 /нэг их наяд хоёр зуун жаран дөрвөн тэрбум зургаан зуун гучин сая зургаан зуун гучин таван мянга хоёр зуун далан зургаан төгрөг дөрвөн мөнгө/ төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн тооллогыг үнэн зөв чанартай хийж, үлдэгдлийг баталгаажуулах, мөн “Чингис хаан” олон улсын нисэх буудлын Шатахууны байгууламж нь “Эрчис Ойл” ТӨХК-д шилжихтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангахад оршино.

2. Тооллого хийх хугацаа

2.1 Шатахуун хангалтын албаны үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг 04/20-04/25-ны өдрийн дотор хийх,

2.2 Шинэ нисэх буудлын бусад хөрөнгийг 04/25-05/20-ны дотор тус тус хийж гүйцэтгэнэ.

3. Тооллого хийх ажлын чиглэл

3.1 Эд хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл, Эд хөрөнгийн тооллого явуулах журам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоол болон холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв, чанартай хийж гүйцэтгэн ажлын тайланг 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулна.

3.2 Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг нэг бүрчлэн тоолж санхүүгийн бүртгэл, хүлээж авсан акт, ТӨБЗГ-н тогтоол, Үнэлгээний тайлан г.м баримтуудтай тулган үлдэгдлийг баталгаажуулах,

3.3 Зөрүүтэй, алдаатай бүртгэсэн хөрөнгүүдийн жагсаалтыг гаргаж, ТӨБЗГ-т хүргүүлэх,

3.4 Хөрөнгүүдийг ашиглаж байгаа салбар нэгжээр нь ялгаж, хөрөнгийн бүртгэлийг шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах,

3.5 Тооллогоор илэрсэн бүртгэлгүй эд хөрөнгийг бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгуулах ажлыг хийх,

4. Тайлан дүгнэлт

4.1 Шатахуун хангалтын албанд харьяалагдах хөрөнгийн тооллогын тайланг 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор,

4.2 Нэгдсэн тайланг 06 сарын 10-ны өдрийн дотор тус тус танилцуулна.